



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/56

Улаанбаатар хот

Баяр наадмын үйлчилгээг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, “Хөдөлмөрийн тухай” хуулийн 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсэг, тус газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ардын хувьсгалын 97 жилийн ой, үндэсний их баяр наадмын өдрүүдэд ажиллах хариуцлагатай эргүүл, жижүүр, тээвэр зохицуулагч нарын хуваарийг нэгдүгээр, Автотээврийн хяналтын улсын байцаагч, жолооч нарын ажиллах хуваарийг хоёрдугаар, нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд ажиллах тээврийн хэрэгслийн нэгдсэн даалгаврыг гуравдугаар, түр ажиллах богино эргэлтийн БЭ:1 “Дүнжингарав худалдааны төв-Төв цэнгэлдэх хүрээлэн-Мишээл экспо” чиглэлийн зураглалыг дөрөвдүгээр, БЭ:2 “Дунд гол-Төв цэнгэлдэх хүрээлэн” чиглэлийн зураглалыг тавдугаар, БЭ:3 “Давааны өртөө-Хүй 7 худаг” чиглэлийн зураглалыг зургаадугаар, “Амгалан-Давааны өртөө” чиглэлд үйлчлэх рейлбус болон нийтийн тээврийн төлөвлөлтийн ерөнхий зураглалыг долоодугаар, үйлчилгээнд ажиллах чирэгчийн хуваарийг наймдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хариуцлагатай эргүүлүүдэд үүрэг болгох нь:

2.1. Хуваарийн дагуу ажиллах жижүүр болон улсын байцаагч, жолооч нарын ажил үйлчилгээнд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж, тухайн өдрийн үйлчилгээний явц байдлын талаар байгууллагын удирдлага, Хотын шуурхай албанд тус тус мэдээлж ажиллах

3. Хариуцлагатай жижүүрүүдэд үүрэг болгох нь:

3.1. Үйлчилгээний цагийн хуваарийн мөрдөлтөд хяналт тавьж, ажил үйлчилгээтэй холбоотой мэдээллийн дагуу шуурхай зохицуулалт хийх, үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж байгууллагууд, зөрчил дутагдал гарсан болон гарч болзошгүй цэг объектуудыг биечлэн шалгаж, зам тээврийн осол, зөрчил гарсан тохиолдолд шаардлагатай арга хэмжээ авах,

3.2. Байгууллагын өрөө, тасалгааны бүрэн бүтэн байдал, хамгаалалт, ус, цахилгааны найдвартай ажиллагааг хангуулах,

1150501300

